ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Ажлын нэр:

“Барилгын хамгаалалтын хашлагын техникийн шаардлагын стандарт”

Ажлын зорилго:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дээр дурдсан журмыг шинээр боловсруулах ажлын техникийн даалгавар боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах

Ажлын даалгавар /шалгаруулсны дараа хийгдэнэ./

Зөвлөхийн гүйцэтгэх үндсэн үүргийг дараах байдлаар тодорхойлно:

- “Барилгын хамгаалалтын хашлагын техникийн шаардлагын стандарт”-ыг боловсруулах олон улсын эх материалыг судлах,
- Судалгааны үр дүн, эх материал болгох бусад орны баримт бичгийн талаар захиалагчтай зөвшилцөх,
- Зөвшилцсөний үндсэн дээр "Техникийн даалгавар"-ыг эцсийн байдлаар боловсруулах.
- Холбогдох танилцуулга бэлтгэх

Зөвлөхөд тавигдах шаардлага

- Мэргэшсэн байдал: Зөвлөх нь салбарын мэргэшлийн зэрэгтэй байх.
- Хууль эрх зүй: Монгол Улсын барилгын салбарын хууль тогтоомж, нормативын баримт бичгийн талаар мэдлэгтэй байх.

Бүрдүүлэх материал

- Зөвлөхийн CV болон мэргэшсэн, зөвлөх зэргийн гэрчилгээний хуулбар.
- Ажлын төлөвлөгөө болон аргачлал, дуусгах хугацааг тодорхой тусгах
- Техникийн даалгавар боловсруулах үнийн санал

Гэрээний нөхцөл ба төлбөр

Техникийн даалгавар Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга баталсны дараа төлбөрийг 100% олгоно.

Зөвлөхөд өгөх мэдээлэл /шалгаруулсны дараа хийгдэнэ./

- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах журам /2024.12.19-ний өдрийн А/696-р тушаал/
- Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо /Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоол/
- Техникийн даалгаврын загвар хүснэгт /А/89-ын дагуу/

Холбоо барих мэдээлэл

- Хариуцсан мэргэжилтэн Н.Батжилмаа
- Утас 99026007

Материал хүлээн авах хаяг

- Цаасан хэлбэрээр ирүүлэх хаяг:
  Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Их тойруу, Баруун 4 зам, Барилгын хөгжлийн төвийн 2 давхар 208 тоот.
- Цахим хэлбэрээр ирүүлэх хаяг:
  Batjilmaa0630@gmail.com

Материал хүлээн авах хугацаа

- Эхлэх хугацаа: 2026 оны 11 сарын 23-ны өдрийн 17:30 цагаас.
- Дуусах хугацаа: 2026 оны 12 сарын 01-ний өдрийн 17:30 цаг хүртэл.